



ЗЭЭЛИЙН БАТЛАН ДААЛТЫН САНГИЙН ТАНИЛЦУУЛГА

2022 оны жилийн эцсийн тайлан



БАНК БУС САНХҮҮГИЙН БАЙГУУЛЛАГЫН ГАЗАР

Монгол Улс, Улаанбаатар хот 15160, Чингэлтэй Дүүрэг, Бага тойруу 3, Засгийн газрын IV
байр. Утас: 51-261668 Цахим шуудан: nbfi@frc.mn

Агуулга

ЗЭЭЛИЙН БАТЛАН ДААЛТЫН САНГИЙН САНХҮҮГИЙН БАЙДАЛ.....	3
ЗЭЭЛИЙН БАТЛАН ДААЛТЫН САНГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА.....	4
Батлан даалтын хэмжээ.....	4
Батлан даалтын дүн, байршил.....	4
Батлан даалтын эх үүсвэр.....	5
Батлан даалт, салбараар.....	6
ЗОХИСТОЙ ХАРЬЦААНЫ ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТ.....	7
Зохистой харьцааны шалгуур үзүүлэлтүүд.....	7
Батлан даалтын ангилал.....	8
ДҮГНЭЛТ, САНАЛ.....	10
Хүснэгтийн жагсаалт	
Хүснэгт 1: Батлан даалт гаргаж буй эх үүсвэр /сая төгрөг/.....	5
Хүснэгт 2: Зохистой харьцааны шалгуур үзүүлэлт.....	7
Зургийн жагсаалт	
Зураг 1: Нийт хөрөнгө /тэрбум төгрөг/.....	3
Зураг 2: Нийт хөрөнгийн бүтэц, хувиар.....	3
Зураг 3: Батлан даалтын хэмжээ.....	4
Зураг 4: Зээлдэгчдийн тоо, байршлаар	
Зураг 5: Батлан даалтын дүн, байршлаар.....	5
Зураг 6: Нийт гаргасан батлан даалт, эдийн засгийн салбараар.....	6
Зураг 7: Зээлийн ангилал	
Зураг 8: Батлан даалтын ангилал.....	8
Зураг 9: Чанаргүй батлан даалтын хувь, хэмжээ /тэрбум төгрөг/.....	9

ЗЭЭЛИЙН БАТЛАН ДААЛТЫН САНГИЙН САНХҮҮГИЙН БАЙДАЛ


Монгол Улсын Их Хурлаас 2012 оны 02 дугаар сарын 10-ны өдөр Зээлийн батлан даалтын сангийн тухай хуулийг баталж, 2012 оны 11 дүгээр сарын 06-ны өдөр Зээлийн батлан даалтын сан байгуулагдсан. Зээлийн Батлан Даалтын Сан нь барьцаа хөрөнгийн дутагдалтай Жижиг дунд үйлдвэр эрхлэгчдэд батлан даалт гаргах ашгийн төлөө бус байгууллага юм. Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.7-д “Зээлийн батлан даалтын сангийн тухай хуульд заасан үйл ажиллагаа” гэж заасны дагуу Санхүүгийн зохицуулах хороо нь Зээлийн батлан даалтын сангийн үйл ажиллагаанд хяналт тавьж, зохицуулан ажилладаг. Санхүүгийн зохицуулах хорооноос 2019 оны 3 дугаар сарын 20-ны өдрийн 46 дугаар тогтоолоор батлагдсан “Зээлийн батлан даалтын сангийн үйл ажиллагааг зохицуулах, хяналт тавих журам”-ын дагуу санхүүгийн тайлан, батлан даалтын дэлгэрэнгүй тайлан мэдээг авч, зохистой харьцааны шалгуур үзүүлэлтүүдийг мөрдүүлж ажиллаж байна.

2022 оны жилийн эцсийн байдлаар Зээлийн батлан даалтын сангийн нийт хөрөнгө 258.6 тэрбум төгрөгт хүрч өмнөх оны мөн үеэс 1.4 хувиар буюу 3.5 тэрбум төгрөгөөр өссөн байна.

Нийт хөрөнгийн 78.7% буюу 201.8 тэрбум төгрөг нь мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгө байна.

Сангийн нийт хөрөнгийн 69.6%-ийг буюу 180.0 тэрбум төгрөг нь өр төлбөр, 30.4%-ийг буюу 78.6 тэрбум төгрөгийг сангийн цэвэр хөрөнгө бүрдүүлж байна.

Зураг 1: Нийт хөрөнгө /тэрбум төгрөг/



Зураг 2: Нийт хөрөнгийн бүтэц, хувиар



Нийт өр төлбөрийн 97.2% буюу 174.9 тэрбум төгрөг нь урт хугацаат өр төлбөр эзэлж байгаа бөгөөд 2.8% буюу 5.1 тэрбум төгрөгийн богино хугацаат өр төлбөр эзэлж байна.

Сангийн цэвэр хөрөнгө 78.6 тэрбум төгрөгт хүрч өмнөх оны мөн үеэс 10.2 хувиар буюу 7.3 тэрбум төгрөгөөр нэмэгдсэн байна.

2022 оны жилийн эцсийн байдлаар нийт орлого 12.2 тэрбум төгрөг ба үүнээс 8.5 тэрбум төгрөгийн цэвэр ашигтай байна.

ЗЭЭЛИЙН БАТЛАН ДААЛТЫН САНГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА


Батлан даалтын хэмжээ

2022 оны жилийн эцсийн байдлаар Зээлийн батлан даалтын сантай нэр бүхий 11 банк, 5 банк бус санхүүгийн байгууллага хамтран ажиллах гэрээтэй бөгөөд үүнээс 6 банк, 1 банк бус санхүүгийн байгууллагаар батлан даалт гарч байна. 2022 оны жилийн эцсийн байдлаар батлан даалтын 75 хүсэлт шинээр ирснээс 42 хүсэлтэд батлан даалт гаргахаар шийдвэрлэсэн байна. Сангийн батлан даалтын үлдэгдэл 2022 оны жилийн эцсийн байдлаар 78.1 тэрбум

төгрөгт хүрч өмнөх оны мөн үеэс 8.5 хувиар буурсан байна. Батлан даалт гаргасан зээлийн үлдэгдэл нь 153.5 тэрбум төгрөгт хүрч өмнөх оны мөн үеэс 8.2 хувиар буурсан байна.

2022 оны жилийн эцсийн байдлаар нийт 580 зээлдэгчид 78.1 тэрбум төгрөгийн батлан даалтын үлдэгдэлтэй байгаагаас 83 зээлдэгчийн 11.7 тэрбум төгрөгийн батлан даалт буюу 15.0 хувь нь чанаргүй байна.

Зураг 3: Батлан даалтын хэмжээ



Батлан даалтын дүн, байршил


Зээлийн батлан даалтын сан 2013 оноос эхлэн нийт 1121 зээлдэгчид батлан даалт гаргасан бөгөөд нийт зээлдэгчдийн 69.2% нь Улаанбаатар хотод, 30.8% нь орон нутгийн зээлдэгчид байна.

Нийт батлан даалтын хэмжээг мөнгөн дүнгээр нь авч үзвэл 78.7% нь Улаанбаатар хотод, 21.3% нь орон нутгийн зээлдэгчдэд батлан даалт гаргасан байна. Энэхүү статистикаас орон нутагт зээлийн батлан даалтын хүртээмжийг нэмэгдүүлж, боломжит зохистой харьцаа хүртэл батлан даалтын хэмжээг нэмэгдүүлэх шаардлагатай байгаа нь харагдаж байна.

Зураг 4: Зээлдэгчдийн тоо, байршлаар



Зураг 5: Батлан даалтын дүн, байршлаар



Батлан даалтын эх үүсвэр

Зээлийн батлан даалтын сан нь 2022 оны жилийн эцсийн байдлаар 16 төсөл болон банк, банк бус санхүүгийн байгууллагаас олгосон зээлд батлан даалт гаргасан байна. Үүнд:

Хүснэгт 1: Батлан даалт гаргаж буй эх үүсвэр /сая төгрөг/

№	Төслийн нэр	Батлан даалтын хэмжээ /сая төгрөг/	Зээлдэгчдийн тоо
1	Ажлын байрыг дэмжих зээл	28,456.4	208
2	Аймгийн жижиг дунд үйлдвэрлэл болон өрхийн бизнесийн үйлчилгээг дэмжих сан	49.2	4
3	Азийн хөгжлийн банкны МОН-3338 төсөл	83,801.6	411
4	АХБ-ны ажлын байр нэмэгдүүлэх төсөл	21.0	2
5	АХБ-ны хөдөө аж ахуй, хөдөөгийн хөгжлийг дэмжих төсөл	300.0	1
6	Барилга, хот байгуулалтын яамны төсөл	250.0	1
7	Жайка	9,711.5	56
8	Жижиг дунд үйлдвэрлэлийг хөгжүүлэх сангийн төсөл	7,864.8	94
9	Монгол 888 төсөл	1,329.0	10
10	Монсеффийн төсөл	420.0	1
11	Нийслэлийн жижиг дунд үйлдвэрлэлийг хөгжүүлэх сан	412.2	9
12	Органик Монгол хөтөлбөр	3.0	1
13	Үйлдвэр, хөдөө аж ахуйн яамны газар тариалангийн үйлдвэрлэлийг тогтворжуулах төсөл /ХХААХҮЯ/	1,626.2	5
14	Үйлдвэр, хөдөө аж ахуйн яамны төсөл	6,933.4	67

	/ХХААХҮЯ/		
15	Хөгжлийн банк	2,499.9	1
16	Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сан	161.0	54
17	Банк	15,953.3	193
18	Банк бус санхүүгийн байгууллага	97.0	3

Батлан даалт, салбараар

Нийт батлан даалт гаргасан салбараар нь ангилж үзвэл боловсруулах үйлдвэр 34.2%, бөөний болон жижиглэн худалдааны үйл ажиллагаа 29.8%, хөдөө аж ахуй ан агнуур ойн аж ахуй 7.7%, эрүүл мэнд ба нийгмийн халамжийн үйл ажиллагааны салбар 6.8%, аялал жуулчлал зочид буудал зоогийн газар 6.4%-ийг тус тус эзэлж байна.

Зураг 6: Нийт гаргасан батлан даалт, эдийн засгийн салбараар



ЗОХИСТОЙ ХАРЬЦААНЫ ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТ

Санхүүгийн зохицуулах хорооноос 2019 оны 3 дугаар сарын 20-ны өдрийн 46 дугаар тогтоолоор батлагдсан “Зээлийн батлан даалтын сангийн үйл ажиллагааг зохицуулах, хяналт тавих журам”-ыг баталсан бөгөөд 2021 оны 9 дүгээр сарын 22-ны өдрийн 385 дугаар тогтоолоор журмын 2.1.5 дахь хэсгийн “1 жилийн” гэснийг “6 сарын” гэж, 2.2.2 дахь хэсгийн “10” гэснийг “3” гэж, 2.2.3 дахь хэсгийн “10” гэснийг “20” гэж, 3.6.2 дахь хэсэгт заасан “15” гэснийг “20” гэж тус тус өөрчилсөн. “Коронавируст халдвар /ковид-19/-ын цар тахлаас урьдчилан сэргийлэх, тэмцэх, нийгэм, эдийн засагт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах тухай” хуулийн 18 дугаар зүйлийн 18.1 дэх хэсэгт заасан хугацаанд буюу 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрийг дуустал 385 дугаар тогтоолыг дагаж мөрдөхөөр заасан.

Зохистой харьцааны шалгуур үзүүлэлтүүд

Хүснэгт 2: Зохистой харьцааны шалгуур үзүүлэлт

Зохистой харьцааны шалгуур үзүүлэлт	Байвал зохих	Тайлангаар	Хангасан эсэх
ӨӨРИЙН ХӨРӨНГИЙН ХҮРЭЛЦЭЭНИЙ ҮЗҮҮЛЭЛТ			
Өөрийн хөрөнгийн байвал зохих доод хэмжээ	5'000'000'000	78,559,968,667.90	Хангасан
Өөрийн хөрөнгийн хүрэлцээний үзүүлэлт	10%-аас доошгүй	30.38%	Хангасан
Гаргасан төлбөрийн баталгаа өөрийн хөрөнгийн зохистой харьцаа	20 дахин нэмэгдүүлснээс хэтрэхгүй	78,089,462,684.77	Хангасан
ТӨЛБӨР ТҮРГЭН ГҮЙЦЭТГЭХ ЧАДВАРЫН ХАРЬЦАА			
Төлбөр түргэн гүйцэтгэх чадварын харьцаа	100%-аас доошгүй	112.08%	Хангасан
АКТИВ ХӨРӨНГИЙН ТӨВЛӨРЛИЙН ҮЗҮҮЛЭЛТ			
Нэг зээлдэгчид гаргах батлан даалт, зээлийн зохистой харьцаа	60%-аас хэтрэхгүй	60.00%	Хангасан
Нэг зээлдэгчид гаргах батлан даалт, өөрийн хөрөнгийн зохистой харьцаа	3%-аас хэтрэхгүй	4.22%	Хангаагүй
Өрийн бичиг өөрийн хөрөнгийн зохистой харьцаа	40%-аас хэтрэхгүй	0.00%	Хангасан
Урт хугацаат өрийн бичиг өөрийн хөрөнгийн зохистой харьцаа	20%-аас хэтрэхгүй	0.00%	Хангасан
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ЗОХИСТОЙ ХАРЬЦАА			
Үйл ажиллагааны зардлын зохистой харьцаа	15%-аас хэтрэхгүй	2.77%	Хангасан
ҮНДСЭН ХӨРӨНГИЙН ҮЗҮҮЛЭЛТ			
Үндсэн хөрөнгийн зохистой харьцаа	5%-аас хэтрэхгүй	1.23%	Хангасан
НӨӨЦИЙН САНГИЙН ХҮРЭЛЦЭЭНИЙ ҮЗҮҮЛЭЛТ			
Нөөцийн сангийн хүрэлцээний үзүүлэлт	4,262,430,821.15	13,858,525,636.32	Хангасан
ЧАНАРГҮЙ БАТЛАН ДААЛТЫН ҮЛДЭГДЛИЙН ЗОХИСТОЙ ХАРЬЦАА			
Чанаргүй батлан даалтын үлдэгдлийн зохистой харьцаа	20%-аас хэтрэхгүй	15.03%	Хангасан


Зээлийн батлан даалтын сан нь “Зээлийн батлан даалтын сангийн үйл ажиллагааг зохицуулах, хяналт тавих журам”-д заасан 12 зохистой харьцааг хангаж ажиллахаас 11-ийг нь хангаж ажилласан байна.

Журмын 2.2.2-т нэг зээлдэгч болон түүний холбогдох этгээдэд гаргах батлан даалтын хэмжээ нь банк, санхүүгийн байгууллагаас авах тухайн зээлийн 60 хүртэл хувь буюу Сангийн өөрийн хөрөнгийн 3 хувиас хэтрэхгүй гэж заасны дагуу батлан даалтын хэмжээ 60 хувийг хангаж ажилласан. Нэг зээлдэгчид гаргах батлан даалт, өөрийн хөрөнгийн зохистой харьцаа 3 хувиас хэтрэхгүй байх гэж заасан боловч 4.22 хувь байгаа нь Санхүүгийн зохицуулах хорооны 2019 оны 3 дугаар сарын 20-ны өдрийн 46 дугаар тогтоолоор батлагдсан “Зээлийн батлан даалтын сангийн үйл ажиллагааг зохицуулах, хяналт тавих журам”-аас өмнө буюу 2016 онд гаргасан батлан даалт байна.

Батлан даалтын ангилал

Зээлийн батлан даалтын сан нь байгуулагдсанаасаа хойш нийт 1121 зээлдэгчдийн 325.7 тэрбум төгрөгийн зээлд 159.9 тэрбум төгрөгийн зээлийн батлан даалт гаргасан байна. 2022 оны жилийн эцсийн байдлаар Зээлийн батлан даалтын сан нь 580 жижиг, дунд үйлдвэр, үйлчилгээ эрхлэгчийн 153.5 тэрбум төгрөгийн зээлд 78.1 тэрбум төгрөгийн батлан даалтын үлдэгдэлтэй байна.

Зураг 7: Зээлийн ангилал



Зураг 8: Батлан даалтын ангилал




Нийт батлан даалт гаргасан зээлийн багцын 79.5% нь хэвийн зээл байгаа нь өмнөх оны мөн үеэс 4.3 хувиар буурсан, 15.7% нь чанаргүй зээл байгаа нь өмнөх оны мөн үеэс 3.2 хувиар, анхаарал хандуулах зээл 4.9% байгаа нь өмнөх оны мөн үеэс 1.1 хувиар тус тус өссөн байна.

Нийт батлан даалтын багцад эзлэх хэвийн батлан даалтын хувь 79.5% буюу 62.1 тэрбум төгрөг болж өмнөх оны мөн үеэс 5.7 хувиар буурсан бол анхаарал хандуулах батлан даалтын хувь 5.5% буюу 4.3 тэрбум төгрөг болж өмнөх оны мөн үеэс 3.9 хувиар, чанаргүй батлан даалтын хувь 15.0% буюу 11.7 тэрбум төгрөг болж өмнөх оны мөн үеэс 1.8 хувиар тус тус өссөн байна.

Чанаргүй батлан даалтын хувь 2020 онд өндөр байгаа нь коронавируст цар тахлын улмаас аж ахуйн нэгжүүдийн бизнесийн үйл ажиллагаа тасалдаж, зээлийн эргэн төлөлт удааширсантай холбоотой юм.

Зураг 9: Чанаргүй батлан даалтын хувь, хэмжээ /тэрбум төгрөг/



ДҮГНЭЛТ, САНАЛ

Зээлийн батлан даалтын сангийн тайлан мэдээг боловсруулахад фина системээр ирүүлж буй улирлын холбогдох тайлан мэдээ нь алдаатай байсан тул тайланг хариуцсан байцаагчаас авч энэхүү тоймыг боловсруулсан бөгөөд тайлан мэдээний үнэн зөв байдалд зайнаас тавих хяналтыг сайжруулахад анхаарах хэрэгтэй байна.

Зээлийн батлан даалтын сангийн үйл ажиллагаа хэвийн, зохистой харьцаануудыг хангаж ажиллаж байгаа бөгөөд зохистой харьцааны шалгуур үзүүлэлтийн дагуу өөрийн хөрөнгийг 20 дахин нэмэгдүүлснээс хэтрэхгүй байх хэмжээнд батлан даалт гаргах боломжтой тул боломжит зохистой харьцааны шалгуур үзүүлэлтэд тохируулан гаргах батлан даалтын хэмжээг нэмэгдүүлбэл зээлдэгчдэд батлан даалтын хүртээмж сайжирна.

Нийт гаргасан батлан даалтын дийлэнх хувийг Улаанбаатар хотын зээлдэгчид эзэлж байгаа бөгөөд орон нутгийн зээлдэгчид батлан даалт гаргуулахад бодлогоор дэмжиж, мэдээлэл өгч ажиллах шаардлагатай байна.

Батлан даалт гаргаж буй эдийн засгийн салбаруудаас боловсруулах үйлдвэр 34.2%, бөөний болон жижиглэн худалдааны үйл ажиллагаа 29.8%-ийг тус тус эзэлж байгаа нь нийт батлан даалтын 64.1%-ийг бүрдүүлж байна. Бусад салбаруудын нийт батлан даалтад эзлэх хувь дээрх 2 салбартай харьцуулахад маш бага байгаа бөгөөд эдийн засгийн салбаруудад батлан даалт нь жигд бус байгааг харуулж байна. Иймд нийт батлан даалтад эзлэх салбаруудын хувийг жигд болгож, салбаруудад олгож буй батлан даалтын хүртээмжийг нэмэгдүүлэхэд анхаарах хэрэгтэй байна.

Батлан даалтын багцын ангилалд эзлэх хэвийн батлан даалт 79.5%, анхаарал хандуулах батлан даалт 5.5%, чанаргүй батлан даалт 15.0% байгаа бөгөөд батлан даалтын чанар болон үүргийн гүйцэтгэлийг сайжруулахад анхаарал хандуулж ажиллах шаардлагатай байна.

Зээлийн батлан даалтын сантай нэр бүхий 11 банк, 5 банк бус санхүүгийн байгууллага харилцаж байгаа бөгөөд цаашид банк бус санхүүгийн байгууллага, хадгаламж зээлийн хоршоодыг Зээлийн батлан даалтын сантай хамтран ажиллахад дэмжлэг үзүүлж, зээлдэгчид батлан даалт гаргуулах боломж бүрдүүлэх шаардлагатай байна. Ингэснээр, банк бус санхүүгийн байгууллага, хадгаламж зээлийн хоршооны харилцагч, барьцаа хөрөнгийн дутагдалтай жижиг, дунд бизнес эрхлэгчид батлан даалт гаргах, санхүүгийн хүртээмжийг нэмэгдүүлэх боломж бүрдэнэ.

БАНК БУС САНХҮҮГИЙН БАЙГУУЛЛАГЫН ГАЗАР